

ХҮМҮҮНЛЭГИЙН УХААНЫ ИХ СУРГУУЛИЙН ХАРЬЯА ХҮМҮҮНЛЭГИЙН ДЭЭД СУРГУУЛИЙН ОЮУТНЫ МЭДЛЭГ, ЧАДВАРЫГ ҮНЭЛЭХ ЖУРАМ

1. Оюутны мэдлэг чадварыг үнэлэх энэ журам нь Магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулиуд кредитийг харилцан хүлээн зөвшөөрөх нэгдсэн тогтолцооны хүрээнд оюутны мэдлэг чадварыг бодьтой үнэлэх, түүний биелүүлсэн кредитийн хөрвөх нөхцөлийг хангахад чиглэнэ.

2. Судалж буй хөтөлбөрөөр оюутан эзэмшвэл зохих мэдлэгийг олж авахын тулд улирлын турш хэрхэн сурч хөдөлмөрлөснөө дүгнүүлэхдээ, тухайн хичээл нь сургалтын төлөвлөгөөний ерөнхий суурь (EC) хэсэгт багтаж байвал заасан багшаар 100 хүртэл оноогоор, мэргэжлийн суурь (MC), мэргэжлийн (M) хэсэгт хамаарагдаж байвал заасан багшаар 70 хүртэл оноогоор, жинхэнэ мэдлэгийн түвшинг улирлын шалгалтын 30 хүртэл оноогоор тус тус заавал дүгнүүлнэ.

Эдгээрийн нийлбэр 100 хүртэлх оноог лавлах хүснэгт ашиглан үсгэн үнэлгээнд шилжүүлнэ.

Лавлах хүснэгт:

	Рейтингийн үнэлгээ	Үсгэн үнэлгээ	Чанарын үнэлгээ
1	96 -100	A	4.0
2	90-95.99	A-	3.7
3	87-89.99	B+	3.4
4	83-86.99	B	3.0
5	80-82.99	B-	2.7
6	77-79.99	C+	2.4
7	74-76.99	C	2.0
8	70-73.99	C-	1.7
9	67-69.99	D+	1.3
10	64-66.99	D	1.0
11	60-63.99	D-	0.7
12	0-59.99	F	0

3. Үнэлгээний голч дүн (GPA). Үнэлгээний голч дүнг тооцохдоо, хичээл бүрийн үсгэн үнэлгээг оноонд шилжүүлэн, улмаар тухайн хичээлийн харгалзах кредитээр үржүүлж, дундажлах замаар тодорхойлно. Оюутан бүрээр улирал бүрийн эцэст тухайн улиралд дүгнэгдсэн хичээлүүдийн хувьд бодогддог **Улирлын Үнэлгээний Голч Дүн** ба оюутны нийт суралцсан хугацаандаа дүгнэгдсэн хичээлүүдийн хувьд бодогддог **Хуримтлуулсан Үнэлгээний Голч Дүн** гэсэн ерөнхий нэг аргачлалтай хоёр тоон утгыг тооцоолж гаргасны эцэст оюутны дүнгийн хуудсыг хэвлэж, хувийн хэрэгт хийнэ. Улирлын болон хуримтлуулсан үнэлгээний голч дүнг дараах ерөнхий томъёогоор тооцоолно.

$$\text{Үнэлгээний Голч Дүн (GPA)} = \frac{\text{чанарын онооны нийлбэр}}{\text{Кредит цагийн нийлбэр}} = \frac{Y_1 * K_1 + Y_2 * K_2 + \dots + Y_n * K_n}{k_1 + k_2 + \dots + K_n}$$

энд,
 Y_1, Y_2, \dots, Y_n - 1, 2, ..., n дугаар хичээлүүдийн чанарын үнэлгээний оноо
 K_1, K_2, \dots, K_n - 1, 2, ..., n дугаар хичээлүүдийн харгалзах кредит

4. Оюутан нь улирал бүрийн эцэст өөрийн сурлагын амжилтандаа дүн шинжилгээ хийж, сургуулийн нэгдсэн стандартад заасан Үнэлгээний голч дүнгийн түвшний шаардлагыг хангаж байгаа эсэхээ хянаж, цаашид суралцах арга барилаа төлөвлөнө.

5. ХДС-ийн Бакалаврын зэргийн дипломыг 2.0 ба түүнээс дээш, Магистрын зэргийн дипломыг 3.0 ба түүнээс дээш үнэлгээний голч дүнтэйгээр суралцсан төгсөгчдөд олгох болно.

6. Тухайн улиралд доод тал нь 15 кредит цуглуулсан ба тухайн улирлын үнэлгээний голч дүн нь 3.6 ба түүнээс дээш амжилт үзүүлсэн оюутнуудын нэрсийг Захирлын нэрэмжит хуудсанд оруулна.

7. Захирлын нэрэмжит хуудсанд нэр нь дараалан 2 болон түүнээс дээш удаа бичигдэж, оюутны эрдэм шинжилгээний хуралд амжилт гаргасан, олон нийтийн ажилд идэвхи санаачлагатай оролцсон оюутнуудыг **"Шилдэг оюутнууд"** гэнэ. Энэхүү нэрсийн жагсаалтанд орсон оюутнуудад тусгай хөтөлбөрт хамруулж суралцуулах, сургуульдаа туслах багш эсвэл ажилтнаар ажиллуулах, бусад гадаадын их дээд сургуульд элсэхэд нь сургуулийн зүгээс дэмжих гэх мэт олон чиглэлээр тусалж ажиллаж болно.

8. Дараах тохиолдлуудад оюутанг **"хангалтгүй"** суралцсан гэж Анхааруулах хуудсанд бичиж доорхи арга хэмжээг сургуулийн зүгээс авч хэрэгжүүлнэ. Үүнд:

8.1. Оюутны тухайн улирлын үнэлгээний голч дүн нь 0.7-оос доош бол **"оюутныг тухайн улиралд хангалтгүй суралцсан"** гэж үзнэ.

8.2. Хангалтгүй суралцсан оюутанд "Анхааруулах хуудас"-нд нэрийг бичиж сануулна.

8.3. "Анхааруулах хуудас"-нд оюутны нэр 3 удаа бичигдвэл тэрхүү оюутныг сурлагаар тэнцээгүй гэж үзэж сургуулиас хасна.

9. Сургуулийн захиргаа, сургалтын төлөвлөлт-мониторингийн алба эрхлэн шинжээчдийн багийг зохион байгуулж мэргэжлийн суурь (М), мэргэшүүлэх (Мш) хөтөлбөрөөс сонголт хийж улирлын эцэст оюутны мэдлэг, багшийн ур чадварыг 30 хүртэлх оноогоор **батлах шалгалт** авч дүгнэнэ. Тухайн улиралд судалж буй дээд боловсролын суурь (ДБС), батлах шалгалтанд сонгогдсон хөтөлбөрөөс бусад бүх хөтөлбөрүүдийн 30 хүртэлх онооны шалгалтыг тухайн хичээл заасан багш авч дүгнэнэ.

10. Сургалтын хөтөлбөрийн дагуу өмнөх холбоонд амжилтгүй буюу багшаас 60 хүртэлх оноог аваагүй тохиолдолд дараагийн хичээл сонгогдохгүй. Уг хөтөлбөрөөр дараагийн улиралд бүлэг бүрдэхгүй тохиолдолд оюутан тухайн хөтөлбөрийг сургалтын төлөвлөгөөний дагуу судална.

11. Оюутан дараах шаардлагыг хангасан тохиолдолд батлах шалгалт болон багшийн 30 хүртэлх онооны шалгалтанд орох эрх нээгдэнэ.

Үүнд:

11.1. Тухайн хөтөлбөрөөр багшаас авах 70 онооноос 42 хүртэлх оноог заавал авсан байх; Хэрэв 42 хүртэлх оноо аваагүй оюутан тухайн хөтөлбөрөө сургалтын төлөвлөгөөний дагуу дахин сонгож судална.

11.2. Сургалтын төлбөрийг зохих журмын дагуу заавал төлж, тэмдэглэгээ хийлгэсэн байх;

11.3. Шалгалтанд орохгүй байх хүндэтгэх шалтгаантай бол урьдчилж заавал мэдэгдэж шаардлагатай бичиг баримт хавсаргах;

11.4. Онлайнар сурч байгаа оюутан зөвлөх багшаараа дамжуулан ямар хөтөлбөрөөр хэдийд шалгалт авах талаарх мэдээлэл авч, тухайн шалгалт авч байгаа цагт минутанд тестийн програм, интернэтээр хүлээн авч, вэб камерийн тусламжтай тестийн материал дээр ажиллаж хураалгана.

12. Оюутан дараах нөхцөлд тухайн хөтөлбөрийн кредитийн үнийн 4000 төгрөгийг төлж тестээр буюу тестийн програмаар СТМА-аас гаргасан хуваарийн дагуу шалгалтаа 1 удаа өгч болно.

12.1. Батлах шалгалт болон багшийн 30 хүртэлх онооны шалгалтанд ороогүй;

12.2. 11.2-р заалтыг зөрчсөн;

12.3. Багшаас авах оноо (70), батлах шалгалт, багшийн 30 хүртэлх онооны шалгалтаас авсан нийлбэр 60 онооноос бага;

12.4. Дээд боловсролын суурь (ДБС) хичээл дээр 60 ба түүнээс бага оноо авсан тохиолдолд;

13. Уг дүрмийн 12-р заалтын дагуу 30 хүртэлх онооны шалгалтанд орсон боловч шалгалтандаа амжилтгүй дүн үзүүлж, багшаас авах оноо (70), батлах шалгалт, багшийн 30 хүртэлх онооны шалгалтаас авсан нийлбэр 60 онооноос бага болсон тохиолдолд тухайн хөтөлбөрөөр кредит нөхөж дахин судална.

14. 11.3-р заалтын дагуу шалтгаан нь бичиг баримтаар нотлогдож байгаа тохиолдолд дараагийн улиралд багтаан тестээр буюу тестийн програмаар СТМА-аас гаргасан хуваарийн дагуу шалгалтаа 1 удаа өгч болно.

15. ХДС-ийн тестийн програм, тестийн санд тухайн хөтөлбөрийн стандартыг хангасан тестээр санг бүрдүүлж оюутныг дүгнэнэ. Дүгнэх тестийг биелүүлэх хугацаа дунджаар 1 цаг 30 минут байна. Улирлын дүгнэх тестийг эгэл (20%), үндсэн (50%), асуудал шийдвэрлэх (30%) гэсэн үндсэн гурван хэсэгтэй зохионо. Эгэл хэсэгт тухайн хичээлийн стандартаар оюутан заавал мэдсэн байвал зохих үндсэн ойлголт, тодорхойлолтуудыг шалгана. Үндсэн хэсэгт оюутан тухайн хөтөлбөрийн хүрээнд эзэмшиж мэдвэл зохих суурь чадвар, дадлыг шалгана. Асуудал шийдвэрлэх хэсэгт оюутан бие даан тодорхой асуудлыг судалсан хөтөлбөрийн хүрээнд шийдвэрлэнэ.

16. Оюутны улирлын явцын үнэлгээг гаргахдаа тухайн оюутны дадлага, семинар, лабораторийн ажлыг гүйцэтгэсэн түвшин, бие дааж хийж гүйцэтгэсэн ажлын үзүүлэлт, тэнхмээс зохион байгуулсан мэдлэг чадварыг тогтоох хяналтын ажлуудын дүн зэргийг нэгтгэн дүгнэнэ.

17. Оюутны суралцсан хугацааны дүнг зөвхөн сургалтын төлөвлөлт-мониторингийн албанаас удирдлагын мэдээллийн сангийн програмаар хэвлэн гаргасан тусгай бланктай тохиолдолд хүчинтэйд тооцно. Иймд шалгалт авсан багш шалгалтын дүнгээ удирдлагын мэдээний санд оруулж уг программаар хэвлэн гаргасан дүнтэй тулгаж гарын үсгээ зурах ба багш, оюутан, сургалтын албаны менежерүүд уг мэдээний үнэн зөвд захиргааны ба эдийн засгийн хариуцлага хүлээнэ.

18. Их сургууль хоорондын оюутан солилцооны журмаар гэрээгээр суралцахаар явж байгаа оюутны суралцаж буй мэргэжил нь ХДС-ийн мэргэжилтэй кредит агуулга дүйцэх бол тухайн оюутанд зайнаас суралцах зөвшөөрөл олгохыг ХДС-ийн захирлын тушаалаар шийдвэрлэнэ. Зайнаас сурах зөвшөөрөл авсан оюутан салбар сургууль, тэнхимтэй гэрээ байгуулах ба ХДС-д судлахаар гэрээлсэн кредит цагийн төлбөрийг бүрэн төлнө. Оюутны шалгалтын дүн нь ХДС-ийн удирдлагын мэдээллийн санд бүртгэгдэнэ.

19. Зайнаас сурах (Online) сургалтанд:

А. ХДС-д 4-өөс дээш улирал амжилттай суралцаж, ҮГД 2.0-оос дээш, нийт 60-аас багагүй кредит цуглуулсан;

Б. Гадаадын их, дээд сургуулиудад амжилттай суралцаж байгаа;

В. Хүндэтгэх шалтгааны улмаас танхимын сургалтанд хамрагдах боломжгүй зэргийг харгалзан үзэж оюутан холбогдох тэнхим, салбар сургуулийн захирлын зөвшөөрөл, ХДС-ийн захирлын тушаалаар хамрагдана.

20. Тушаал гарснаар сургалтын алба оюутны бүртгэлд нэмэлт тэмдэглэгээ хийж, судлах хичээлийн жагсаалтыг санал болгон сонголтыг хийлгэнэ. Хичээл сонголт хийснээр оюутан багштайгаа өөрийн вэбээр дамжуулан тухайн хөтөлбөртэй холбогдол бүхий мэдээллийг авч, өгсөн даалгаврыг гүйцэтгэж кредитийг бүрэн судалж, өөрийн мэдлэг чадвараа уг журмын дагуу үнэлж дүгнүүлнэ.

21. Тухайн улирлын эцэст оюутан бүрээр бодогддог улирлын үнэлгээний голч дүнг тооцож гаргахад дараах тэмдэглэгээнүүд хэрэглэгдэнэ. Үүнд:

U - Оюутан кредит шууд тооцох шалгалтын дүнг зөвшөөрөөгүй

E - Улирлын шалгалт өгөөгүй

R - Тухайн хичээлд дахин суралцахаар шийдсэн

W - Хичээлийн явцад суралцахаас татгалзаж хаясан

Эдгээр тэмдэглэгээнд харгалзах үнэлгээний оноо 0.0 байна. Оюутан нь жилийн дотор дээрх тэмдэглэгээтэйгээр шалгагдсан тухайн хичээлийг дахин судалж, "A-F" үнэлгээтэйгээр шалгуулах үүрэгтэй.

21.1. Оюутан кредит шууд тооцох шалгалтын дүнг зөвшөөрөөгүй –

"U" Uncomplete

Оюутан тухайн хичээлийг өөрийн мэдлэг, дадлага, чадварыг хангалттай гэж үзвэл кредит шууд тооцох 30 хүртэл онооны шалгалтанд өөрийн хүсэлтээр орж болно. Энэ тохиолдолд уг хичээлийг хариуцсан профессор нь оюутантай ярилцлага хийж шууд шалгалтанд орох зөвшөөрлийг олгоно.

Кредит шууд тооцох шалгалтыг зөвхөн томилогдсон комисс авах ба шалгалтанд орохын өмнө тухайн хичээлийн кредитийн үнийг бүрэн төлсөн байна.

Энэхүү шалгалтыг оюутан амжилттай өгсөн тохиолдолд тухайн хичээлийн кредитийг оюутанд шууд олгоно. Хичээлийн үнэлгээний хувьд оюутны шалгалтанд авч болох 30

хүртэлх оноог 3.33 гэсэн оноогоор үржүүлж, уг хичээлийг бүтэн үнэлэх 100 хүртэл оноод шилжүүлнэ.

Оюутанд сургалтын төлөвлөгөөнд тусгайлан тэмдэглэсэн одтой хичээлээр кредит шууд тооцох шалгалт өгөхийг зөвшөөрөхгүй.

Оюутан нь хичээлийн жилийн нэг улиралд 30 хүртэл онооны кредит шууд тооцох 3 хүртэл шалгалтанд орох эрхтэй.

Оюутан кредит шууд тооцох шалгалтын үр дүнд сэтгэл дундуур байвал шалгалтын дүнгийн хуудсанд **"U"** тэмдэглэгээг тавиулж болно.

Шалгалтын хуудсанд **"U"** тэмдэглэгээг тавигдсан хичээлийг оюутан шинээр дахин сонгож судлаад 70 онооны болон улирлын шалгалтанд орж "A-F" гэсэн үнэлгээ авсан байх шаардлагатай.

21.2. Оюутан улирлын шалгалт өгөөгүй- "E" Exam incomplete by the student

Оюутан ямар нэг хүндэтгэх шалтгааны улмаас улирлын шалгалтанд ороогүй тохиолдолд **"E"** тэмдэглэгээг тавиулж болно. **"E"** тэмдэглэгээ авсан хичээлээр оюутан дараа жилийн дотор багтаж заавал шалгалт өгсөн байна.

21.3. Оюутан тухайн хичээлийг дахин суралцахаар шийдсэн –

"R" Repeating a course

Оюутан өөрөө уг хичээлд дахин суралцах хүсэлтэй, эсвэл хичээлийн эцсийн үнэлгээнд сэтгэл дундуур байгаа тохиолдолд **"R"** тэмдэглэгээг дүнгийн хуудсанд сургалтын нэгдсэн хуанлид заасан хугацаанд тавиулж болно.

Оюутан нь тухайн хичээлээр энэ тэмдэглэгээг сургалтын албанаас тавиулсан тохиолдолд уг хичээлийг жилийн дотор дахин судлаж үзэж, үнэлгээг дээшлүүлэх эрхтэй болж байгаа юм. Энэ тохиолдолд **нэгдүгээрт**, уг хичээлийг дахин бүрэн судлаж багшийн болон улирлын шалгалтын онооны нийлбэрээр, **хоёрдугаарт** уг хичээлийг өмнө судлаж үзэж байхдаа багшийн 70 онооноос 50-аас дээш оноо авсан байвал кредит шууд тооцох шалгалтаар тус тус үнэлүүлж болно.

Оюутан нь 3 ба түүнээс олон улирал өнгөрсний дараа тодорхой хичээлийн үнэлгээг дээшлүүлэхийг хүсвэл уг хичээлийг дахин сонгож судлаж үзэхийг анхааруулж байна. Оюутан дахин суралцахаар бүртгүүлсэн хичээлийг, шинээр үзэхээр сонгосон хичээлүүдийн нэгэн адилаар бүртгэж төлбөрийг төлүүлнэ.

Харин кредит шууд тооцох шалгалтанд орох үед төлбөл зохих кредитийн үнийг бүрэн төлнө.

21.4. Оюутан хичээлийн явцад тухайн хичээлд суралцахаас татгалзаж хаясан- "W" Withdrawal

Оюутан ямар нэгэн шалтгаанаар бүртгүүлсэн хичээлдээ суугаагүй, лаборатори, дадлага, бие даалтын ажлыг хийгээгүй, хөтөлбөрийн шаардлагыг хангаагүй, цаашид суралцах эсэх нь тодорхойгүй бол багш шууд **"W"** тэмдэглэгээ тавина.

Тэмдэглэгээ авсан оюутан харъяа мэргэжлийн тэнхмээс тодруулга хийж дараах тэмдэглэгээг тавина.

"WA"-хаясан,

"WP"-шилжсэн,

"WC"-сахилгаар тэнцээгүй,

21.5. Кредит - "CR" Credit granted

21.5.1 Магадлан итгэмжлэлд орсон дээд сургууль, коллежиудаас шилжин ирж буй оюутнуудын үзэж судалсан хичээлийн кредитийг бүрэн тооцож, кредитээ тооцуулж болно.

22. Аливаа шалгалтын үнэлгээний талаар маргаан гарвал Салбар сургууль, тэнхмээс томилогдсон комисс тухайн хөтөлбөрөөр оюутан эзэмшсэн байх мэдлэг чадварын жагсаалтыг баримтлан шийдвэрлэнэ. Оюутан өөрийн санаачлагаар **U,E,R** тэмдэглэгээ авах эрхтэй. Шалгалтын дүнгийн хуудсанд ийм тэмдэглэгээ авахаа зөвшөөрч оюутан гарын үсгээ зуран баталгаажуулна. Тэмдэглэгээ нь уг оюутны нэрийг Сургалтын албанаас гаргадаг АНХААРУУЛАХ ХУУДАС-нд түр оруулахгүй байх үндэслэл болно.

23. Харилцаа, ёс суртахууны доголдол гаргасан оюутныг мэргэжлийн тэнхим болон салбар сургуулийн зөвлөлгөөнөөр хэлэлцэн протокол хөтлөж шалгалтаас түдгэлзүүлэх, сургуулиас хасах хүртэл арга хэмжээг авч болно.

24. ХДС-ийн Бакалаврын зэргийн дипломыг дараах шаардлага хангасан төгсөгчдөд олгоно. Үүнд:

- Сургалтын төлөвлөгөөний дагуу нийтдээ 120-иос доошгүй кредит судалсан.
- Төгсөлтийн шалгалт болон диплом хамгаалалтанд 70 ба түүнээс дээш оноо авсан, **ҮГД 2.0** -оос дээш, сургалтын төлөвлөгөөнд заагдсан мэргэжлийн 3 гол хөтөлбөрт (*) -той хичээлд "С" -гээс доошгүй үнэлгээ авсан төгсөгчдөд **бакалаврын зэрэг** олгоно.

25. Сургалтын төлөвлөгөөний дагуу 120 –иос доошгүй кредит судласан, суралцсан хугацааны **ҮГД 1.7**-оос дээш, төгсөлтийн шалгалтанд 70-аас түүнээс доош оноо авч, сургалтын төлөвлөгөөнд заагдсан мэргэжлийн 3 гол хөтөлбөрт "С"-гээс доош үнэлгээ авсан төгсөгчдөд **диплом** олгоно. Дипломын хавсралтад судалсан бүх хөтөлбөрийн үнэлгээг бичнэ.

26. Төгсөлтийн дипломын ажил, төгсөлтийн шалгалтанд 90-ээс дээш оноо авсан, суралцсан хугацааны **ҮГД 3.7** -гоос дээш голч дүнтэй төгсөгчдөд **Онцгойлох диплом** олгоно.

27. ХДС-ийг дипломын зэрэгтэй дүүргэсэн төгсөгч боловсролын бакалаврын зэрэг авах зорилгоор төгссөнөөс хойш 4 жилийн дотор саналаа гарган бакалаврын зэргийн нөхөн сургалтанд хамрагдан шалгалт өгч болно. Бакалаврын зэрэг нөхөн олгох шалгалтыг их сургуулийн захирлын тушаалаар баталсан комисс авна.

28. Оюутны онцгой авъяас чадварыг харгалзан, эзэмших мэргэжлээр нь судалгааны ажил хийлгэж, тусгай хөтөлбөрөөр эрдэмтэн багш нарыг дагалдуулан сургаж болно. Ийм оюутны суралцсан хугацааны мэргэжлийн болон мэргэшүүлэх хөтөлбөрт 90-ээс дээш хувь нь "А" гэсэн үнэлгээтэй, өөрөө хүсэлтээ гаргасан бол магистратурт давхар суралцуулж болно.

29. Магистрантаар элсэгчийн бакалаврын сурлагын голч дүн нь 2.5 (75%) -аас, доошгүй байна. Магистрант, докторантын эзэмшсэн мэдлэг, чадварын үнэлгээний тогтолцоо нь бакалаврын сургалтын адилаар 100 оноо ба (A, A-, B+, B, B-, C+, C, D+, D, D-, F) үнэлгээнд үндэслэнэ.

30. Дараахи тохиолдолд оюутныг сургуулиас хасч мэдээллийн санд өөрчлөлт хийнэ.
Үүнд:

- Сургалтын төлбөрөө Оюутныг үнэлэх дүгнэх журмын 31-д заасан хугацаанд багтаан төлөөгүй,
- ХДС-ийн дүрмийг ноцтой зөрчсөн, сахилга батын зөрчил гаргаж сургуультай байгуулсан гэрээг зөрчсөн тохиолдолд;
- СУРГУУЛИАС СУРЛАГААР ХАСАХ МЭДЭГДЭЛД нэр нь орсон оюутан тухайлсан хөтөлбөрүүдийн шалгалт, кредитийн тооцоог энэ журамд заасан хугацаанд багтаан хийгээгүй бол сурлагаар тэнцэхгүй шалтгаанаар,
- Оюутан өөрийн санаачлагаар сургуулиас гарахыг хүссэн өргөдлөө гаргасан,
- Захирлын тушаалаар чөлөө авалгүй нэг сараас илүү хугацаагаар сураггүй алга болсон.

Сургуулиас хассан тохиолдолд тухайн хичээлийн жилийн сургалтын төлбөрийг оюутанд буцаан олгохгүй.

31. Сургалтын төлбөр төлөх болон буцаах нөхцөлүүд:

- Сургалтын төлбөртэй холбогдох асуудлыг оюутны бичгээр гаргасан өргөдлийг харгалзан захирлын тушаалаар шийдвэрлэнэ. Сургуулийн захиргаанд /Сургалтын нэгдсэн албанд/ өргөдлөө бичгээр өгөөгүй байсан бол сургалтаас чөлөөлөх өдрийг бичгээр өргөдөл өгсөн өдрөөр тасалбар болгон, өргөдөл өгсөн өдөр хүртэл хугацааг суралцсанаар тооцно.
- Шинээр элсэж буй оюутнууд бүртгүүлж анги хуваарьлуулахдаа сургалтын төлбөрөө бүрэн төлсөн байна.
- 2-4 дүгээр курсийн оюутнууд сургалтын төлбөрийг 10 дугаар сарын 01-ний дотор төлсөн байна.
- 2-4 дүгээр курсийн оюутнууд сургалтын төлбөрийг тодорхой шалтгаанаар хичээлийн жилийн улирлаар 2 хувааж төлөх бол II улирлын төлбөрийг 2 дугаар сарын 01-ний дотор төлөх үүрэгтэй.
- Сургалтын төлбөрөө **дээрхи хугацаанд багтаан** хийгээгүй оюутны сургалтын гэрээг захиргааны санаачлагаар цуцлан захирлын тушаал гарна.
- Эрүүл мэндийн шалтгаанаар сургуулиас чөлөөлөгдөх нөхцөлд эмч нарын зөвлөлгөөний магадлагааг харгалзан тушаал гарсан өдрөөс хойших хугацааны сургалтын төлбөрийг бүрэн хэмжээгээр буцаан олгоно.
- Хичээлийн жилд хүндэтгэх шалтгаанаар хичээлд суугаагүй байгаад сургуулиас гарч буй оюутанд энэ тухай захирлын тушаал гарсан өдрөөс хойших хугацааны сургалтын төлбөрийн 75 хувийг буцаан олгоно.
- Өөрийн хүсэлтээр буюу бусад шалтгаанаар сургуулиас гарсан тохиолдолд суралцаагүй хугацааны сургалтын төлбөрийн 50 хувийг буцаан олгоно.
- Тухайн улиралд судалвал зохих нийт кредитийн 75-аас дээш хувьд сул дүн үзүүлж сурлагаар хасагдсан, шалтгаангүйгээр болон сураггүй алга болсон, эсвэл сургуулиас өөрийн хүсэлтээр бүрмөсөн гарч байгаа тохиолдолд оюутны сургалтын төлбөрийн буцаалт хийгдэхгүй.